ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Барилга угсралтын ажлыг Барилгын норм ба дүрэм /БНбаД/,Стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэнэ. Барилга угсралтын ажлыг дулааны улиралд хийхээр тооцоологдсон байгаа тул БН ба Д-ийн зохих заалтыг баримтлан гүйцэтгэнэ.

Тендерийн бичиг баримтанд заавал бүрдүүлж ирэх материал:

- Барилгын засварын ажил гүйцэтгэх үе шатны график
- Талбайн зохион байгуулалтын зураглалыг заавал ирүүлнэ.

Бүх үе шатны ажлууд тухай бүрт нь хэмжилт хийж фото зургаар баталгаажуулах, зургийн авторын хяналтыг заавал хийлгэсэн байна.

Барилга угсралтын ажлыг дулааны улиралд гүйцэтгэнэ. БН ба Д-ийн зохих заалтуудыг баримтлан гүйцэтгэнэ.

Архитектур төлөвлөлт: Уг барилга нь Баянхонгор аймгийн Заг сумын Хар усны багийн төвийн контор болон тэжээлийн агуулахын барилга нь 8*18м ба 1 давхар ба өрөөнүүдийн зориулалт нь хурлын танхим, эмчийн өрөө, багийн Засаг даргын өрөө, үүдний өрөө, тайз байхаар төлөвлөсөн болно.

Суурийн ажил: Хөрс нь цэвдэгтэй нөхцөлд хамаарагдах тул суурь хэсгийн шалны доорхи хөрсийг хэвийн байлгахын тулд суурийг цутгахдаа салхижуулалтын нүх гаргаж бетон шал хийж, давхар хучилт дам нуруу тавин тусгаарлалт хийн шаллах хэрэгтэй.

Ханын ажил: Ханын өрлөгийн үндсэн гадна ханыг даацын хүрмэн блокоор өрж 10 см хөөсөнцөр дулаалга хийж гадна талаар нь 12 см-н тоосго давхарлаж, гадна дотор давхар ханыг хооронд нь өрлөгийн завсар ф6мм арматур хадаасаар бэхлэж өгөх ба өрлөгийн хана уулзварууд өнцөг булан бүрт үйлдвэрт хийгдсэн торыг өрлөгийн хэвтээ тэнхлэгийн дагуу тавина.

Хучилтын ажил: Хучилтыг модон материалаар шувуу нурууны хадмал банзан татангаар өгөх ба адар бамбайг 4см-н банзаар хийж бүх модон материалд галаас хамгаалах бодис 2 дахин нэвчүүлэн түрхэх хэрэгтэй. Шувуун нурууны 2 талын хормойн хэсгийг төмөр бетон бүснээс гарсан бэхэлгээнд боолтоор боож өгнө. Шувуу нурууг газар дээр нь зургийн дагуу сайтар нягтлан хэмжиж хийх хэрэгтэй. Хуудас ББ-9, ББ-10-д үз.

Ялууны ажил: Цутгамал ялууг зурагт ББ-5, ББ-6 хуудсанд заасан газруудад хэв хашмалтай сайтар чанартай цутгах ба зурагт тусгагдаагүй бусад цонхнуудын дээд төвшин нь төмөр бетон бүсний доод төвшинд тохирч байгаа тул ялуу цутгах шаардлагагүй. Ялууг М150 маркийн бетоноор цутгах ба бүрэн бэхэжсэний дараа хэв хашмалыг авч дараагийн ажлыг үргэлжлүүлэх хэрэгтэй.

Төмөр бетон бүсний ажил: Төмөр бетон бүсийг Г1040.1.3-г баримтлан хэв хашмалтай В15 ангийн бетоноор цутгах ба бетоны марк, зуурмагт маш анхаарах хэрэгтэй. Төмөр бетон бүс нь цонхны хэсэгт ялууны үүрэг давхар гүйцэтгэх учир

цутгалтыг маш сайн хийх шаардлагатай. Төмөр бетон бүсийг цутгахдаа шувуу нурууны бэхэлгээг алгаслалын хэмжээгээр суулгаж өгнө.

Хаалга, цонхны ажил: Хаалга, цонхны хэмжээг байгуулалтын зурган дээр үндсэн нүхний хэмжээгээр өгсөн болно. Барилгад хэрэглэх хаалга цонх нь Монгол улсад мөрдөж буй стандартын шаардлагыг хангасан үйлдвэрт хийгдсэн байх ёстой. Цонх нь хуванцар рамтай вакуум шилэлгээтэй байх ба дотор хаалганууд сайн чанарын модон хаалга угсарч, гадна хаалганд гоёлтой төмөр хаалга суулгана. Хаалга суулгах нүхний 2 талд 2-оос доошгүй хар тосонд нэвчүүлсэн модон тоосго суулган түүндээ хаалганы хайрцгийг бэхлэн өгч шахдаг хөөсөөр дулаалж өгнө.

Шалны ажил: Шалыг хуудас БА-9, ББ-14, ББ-15-д үзүүлсний дагуу иргэн ба олон нийтийн барилгын шалны альбом цуврал 02-5-ийн хэсэглэл 1.3-н холбогдох хэсэглэл зааврын дагуу материалаар хийнэ.

Таазны ажил: Бүх өрөөний таазыг шувуун нурууны ул нурууны доороос өнгөтэй 1.2*1.2м хэмжээтэй 4мм зузаантай магнум хавтангаар цэвэр үзэмжтэй тэгш хэмд доторлож өгнө. Хавтангийн цаана ус тусгаарлагч плёнка буюу хар цаас хадаж өгнө.

Дээврийн ажил: Шувуун нурууны дээр хадсан сараалж банзан дээр үйлдвэрийн хэвлэмэл төмрөөр дээвэрлэж 2 талын дээврийн хормойд усны хагалбар гарган дээвэрлэж өгнө. Хоёр талын фронтоныг тоосгоор өрж салхивч цонх гаргаж өгнө.

Гадна заслалын ажил: Барилгын гадна эргэн тойронд довжооноос бусад хэсэгт ус зайлуулах хаяавчийг 60 см өргөнтэй 10см-н зузаантай 3%-н налуутай В7.5 ангийн бетоноор хийж 2см зузаантай цементэн зуурмагаар өнгөлж өгнө. Гадна үүдэнд бетон довжоог цутгаж өгөх ба хаяавч довжооны доорхи хөрсийг 50см гүнтэй 1.8г/м3 болтол нягтруулсны дараа бетоны ажлыг хийнэ.

Дотор заслалын ажил: Дотор заслалын ажлыг хийхдээ хуудас БА-6, БА-7, БА-8, БА-9, БА-12-д үзүүлсний дагуу сайтар чанартай гүйцэтгэх хэрэгтэй.

Дотор гэрэлтүүлгийн ажил: Тэжээлийг тухайн шаардлагатай үед зөөврийн мотороор 220 вольтоор тэжээх захиалагчийн саналыг харгалзан тусгав. Оролтыг зөөврийн мотороос ГС-1 самбарын оролтын автоматад өгөх юм. Дотор гэрэлтүүлгийг БНбД23-02-08-н дагуу гүйцэтгэсэн ба гэрэлтүүлэг 2*36вт люминесцент чийдэнтэй таазанд ил тавих ердийн гэрэлтүүлэг тавина. Дотор бүх утасны монтажийг зэс голтой поливинилхлорид тусгаарлагчтай ПВ-660 маркийн утсаар ханын шавардлага доор, далд таазаар таазны материалын цаана түдүүлдэж тавина. ГС-1 самбарт эх орны үйлдвэрийн "МОН-HOURS" ХХК-ны самбар тавихаар тусгасан ба тэжээлийн шугам, гэрэлтүүлэг розетокийн сүлжээг хамгаалах зорилгоор ВА47-29-23, АД12-29-16 маягийн автоматууд төлөвлөв. Гэрлийн автоматтай самбарыг зурагт заасан хананд 1.6м өндөрт тавих ба тэжээлийн шугамыг розеток,

гэрэлтүүлэгчээр тусад нь бүлэглэн холбоно. Бүх угсралтыг аюулгүй ажиллагааны норм дүрмийн дагуу мэргэжлийн байгууллага хүнээр гүйцэтгүүлэх хэрэгтэй.

<u>Өвсний агуулахын барилгын ажил:</u> Уг барилга нь 20*12м хэмжээтэй 1 давхар шувуу нуруу, төмөр дээвэртэй, агуулахын зориулалтаар ашиглахаар энгийн төлөвлөлттэй байна. Өвсний агуулах нь 2 талдаа машин гарах нэвт хаалгатай, суурийг бетоноор цутган төмөр бетон багана арматурчлан цутгаж төмөр бетон бүстэй болбож рамлах ба тэнхлэг А,1.7-Г.1.7-н дагуу цутгамал багананд булан төмөр бэхэлгээ суулган задгай торон хана бэхлэж бэтүүлэх тэнхлэг 1-А-Г-н дагуу блокон өрлөгөөр фронтоны хамт ханыг өрнө. Шал бетон бэлтгэл дээр цементэн тэгшилгээ хийж шаллах ба гадна үүдэнд i=0.06 налуутай пандус цутгаж өгнө. Хучилтыг шувуу нуруу хийж сараалж банз хадаж төмрөөр дээвэрлэнэ. Шувуун нурууны бэхэлгээг төмөр бетон бүс цутгахдаа шувуу нурууны алгаслалын хэмжээгээр суулгаж өгөх хэрэгтэй. 2 талын том хаалгыг дотроо жижиг хаалгатайгаар газар дээр нь бэлдэж өгнө.

Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:

Монгол улсын Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн **14.3-т "Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх тохируулах хугацаа нэг жил байна", 14.6-т "энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна"** гэсэн заалтын дагуу баталгаа гаргаж өгнө.

Барилгын ажлыг чанаргүй хийсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгөх бөгөөд гүйцэтгэсэн ажилдаа хэрвээ барилгын зураг төсөлд өөрчлөлт оруулах, материал хийц хэсэг өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад албан бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс 28 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд зургийн дагуу гүйцэтгэнэ. Дээрхи техникийн тодорхойлолт заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагчид эрхийнхээ дагуу барилгын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН
БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Д.ИХБАЯР

Барилгын зураг төсвийн « ЦЭСДА» ХХК

Зургийн шифр БХ-26\15-13”\18

Төсвийн шифр БХ-79-3 \17

Баянхонгор аймаг Заг сум Багийн төвийн конторын барилга болон тэжээлийн агуулахын барилгын ажлын төсөв

Нийт төсөвт өртөг 98 033 573 төгрөг

Захирал.....Ц.Орхонтамир

Мэргэшсэн төсөвчин.....Ц.Орхонтамир

Баянхонгор хот 2017

АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

ГАЗРЫН АЖИЛ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Суурийн шуудуу мех-аар ухаж шороог овоолох	м3	22
2	Суурийн шуудуу гараар засаж ухах	м3	12
3	Суурийн доор элсэн дэвсгэр хийх	м3	1.5
4	Суурийн хажуугаар шороо мех-аар чигжих	м3	11
5	Суурийн хажуугаар шороо гараар чигжих	м3	8
6	Хөрс нягтруулагчаар нягтруулах	м3	22
7	Шал довжооны доор шороо хийж нягтруулах	м3	23

СУУРИЙН АЖИЛ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Чулуут бетон шугаман суурь цутгах м100	м3	32
2	Хамар хананы доорхи суурь цутгах В12.5	м3	8

ШАЛНЫ АЖИЛ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Хөндий шал цутгах м200	м3	10.89
2	Салхивчийн хөндийд ган яндан хоолойн голч d=150мм угсрах	м	6
3	Тоосгон тулгуур өрөх	м3	6.56
4	Дүнзэн дам нуруу угсрах	м3	2.61
5	Банзан зулавчтай модон хучилт хийх	м3	7.33
6	Давхар дундын шалан дор нэг үе хар цаас дэвсэх	м2	141
7	Дүнзэн дэр мод дулаалгын хамт угсрах	м2	3.61
8	Хучаасын модон хийцүүдэд галаас хамгаалах бодис түрхэх	м2	76
9	Шалны бетон бэлтгэл хийх м150	м3	11.28
10	20 мм зузаан цементэн тэгшилгээ хийх	м2	141
11	1 үе тусгаарлалт хийх	м2	19.2
12	Керамзитаар дулаан ба дуу тусгаарлалт хийх	м3	4.8
13	Паркетан шал шахах	м2	113
14	Үүдний хэсгийн шаланд вааран хавтанцар наах	м2	8.8
15	Эмч болон Багийн засаг даргын өрөөнд паркетан шал шахах	м2	19.2

ХАНА, ХАМАР ХАНЫН АЖИЛ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Хүрмэн бетон гулдмайгаар гадна хана өрөх	м3	55
2	Хананд хөөсөнцөрөөр нэмэлт дулаалга хийх	м2	141
3	Тоосгон өнгөлгөө өрөх 12см	м2	141
4	Дотор тоосгон хана өрөх	м3	2.53
5	Ханын босоо гадаргууд ус тусгаарлалт хийх	м2	32

ХААЛГА, ЦОНХНЫ АЖИЛ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Төмөр хаалга суулгах ТХ21-10	ш	2
2	Хаалга угсрах ХБ21-10	м2	6.3

АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

3	Давхар рамтай вакуум хаалга угсрах ВХ21-10	м2	4.2
4	Хаалганы зай завсрыг баллонтой шүршдэг хөөсөөр чигжиж дулаалах	м2	14.7
5	Давхар рамтай вакуум цонх угсрах 15-14	м2	10.5
6	Давхар рамтай вакуум цонх угсрах 13-14	м2	3.64
7	Давхар рамтай вакуум цонх угсрах ВЦ06-14	м2	1.68
8	Цонхны зай завсрыг баллонтой шүршдэг хөөсөөр чигжиж дулаалах	м2	16
9	Цонхонд гантиг чулуун хавтангаар тавцан хийх	м2	8
10	Цонхны гадна цагаан төмрөөр хаяавч хийх	м2	4

ЦУТГАМАЛ ЯЛУУ, ХАНЫН ТОРНЫ АЖИЛ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Төмөр бетон ялуу цутгах М-150	м3	0.54
2	Модон ялуу хийж угсрах	ш	1
3	Ханын тор тавих	м	96
4	Ханын тор тавих	м	26
5	Ханын тор тавих	м	8
6	Ханын тор тавих	м	11

ТӨМӨР БЕТОН БҮСНИЙ АЖИЛ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Хэв хашмалтай бүс төмөр бетоноор цутгах м-200	м3	10.9

ХУЧИЛТЫН АЖИЛ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Банзан зулавчтай модон хучилт хийх	м3	5.06

ДЭЭВРИЙН АЖИЛ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Шувуун нурууны бэхэлгээ суулгах	тн	0.023
2	Банзан шувуу нуруу угсрах	м3	10
3	Дээврийн сараалж банз хадах	м2	117.6
4	Цэвэр банзан карниз угсрах	м2	10.5
5	Дээврийн хормойвч банз угсрах	м2	10.5
6	Адрын бамбай зулавчтай модон хучилтад эрдэс хөвөн хавтангаар дулаалга хийх	м2	240
7	Төмөр дээвэр хийх	м2	220
8	Барилгын гадна ус зайлуулах хоолой хийх	м2	20
9	Дээврийн хормойвчийг төмрөөр хийж усны хагалбар гаргах	м2	11.3
10	Дээврийн малгайвч төмөр хийх	м2	12.6
11	Дээврийн сараалж ба хучаасын модон хийцүүдэд галаас хамгаалах бодис түрхэх	м2	100
12	Дээврийн салхивчийн цонх угсрах Ц06-06	ш	2
13	Тоосгон фронтон өрөх	м2	12
14	Фронтон гараар шавардах	м2	12
15	Фронтон шохойдох	м2	21

АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

16	Фронтоны хөвөө карниз бэлтгэж угсрах	м	20

БУСАД АЖИЛ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Тоосгоор яндангийн хамгаалалт өрөх	м3	0.4
2	Яндан гараар шавардах	м2	10
3	Яндан шохойдох	м2	10
4	Малгайвч төмөр хийх	м2	1.6
5	Асбестоцементэн долгионт хуудсаар яндан ороох	м2	1.8
6	Цайрдсан төмрөөр асбестон гадаргуу бүрэх	м2	1.2
7	Асбестоцементэн долгионт хуудсаар халаалтын зуухны доодох шалыг бүрэх	м2	1.8
8	Гөлмөн төмрөөр шалны асбестон гадаргуу бүрэх	м2	2.1

ДОТОР ЗАСЛЫН АЖИЛ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Дотор хана шавардаж замаскдах	м2	170
2	Дотор хана эмульсдэх	м2	170
3	Таазанд шавардлага хийх	м2	142
4	Таазанд модон рам зангидаж хавтан өнгөлгөө угсрах	м2	142

ГАДНА ЗАСЛЫН АЖИЛ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Гадна хананы тоосгоны хооронд сайн чанарын шавардлага хийх	м2	140
2	Бетон хаяавч цутгах	м3	2.3
3	Цоколийн гадна тал барзайлгах	м2	21
4	Цоколийн гадна тал бор шаргал өнгийн зосоор будах	м2	21
5	Заслалын шат угсрах буулгах	м2	22
6	Зааланд уур сорох салхивчийн сэнс суулгах	ш	2

ГАДНА ДОВЖООНЫ АЖИЛ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Довжооны суурь ухах	м3	0.14
2	Довжоо цутгах	м3	0.32
3	Гадна довжоонд цементэн тэгшилгээ хийх	м2	4
4	Тэгш гадаргуу дээр чулуун хавтан суулгах	м2	4
5	Чулуун хавтан дээр резинэн дэсгэр наах	м2	4

ХБИРГЭДИЙН ТЭРГЭНЦЭРИЙН ЗАМЫН АЖИЛ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Гадна үүдэнд тэргэнцэрийн довжоо цутгах	м3	0.7
2	20 мм зузаан цементэн тэгшилгээ хийх	м2	3.5
3	Бариул суулгах	ш	2

ДОТОР ГЭРЭЛТҮҮЛЭГЧИЙН АЖИЛ

АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Гэрэлтүүлэгчийн самбар тавих	ком	1
2	Дефференциал автомат угсрах	ш	1
3	ВА47-29 автомат угсрах	ш	1
4	Шугаманд ВА47-29 автомат угсрах	ш	1
5	Өдрийн гэрэлтүүлэгч тавих	ширхэг	6
6	Дүүжлүүр гэрэлтүүлэгч угсрах	ширхэг	4
7	Унтраалга розетканы хайрцаг угсрах	ш	12
8	Утас салбарлах хайрцаг угсрах	ш	7
9	Далд угсрах унтраалга тавих	ширхэг	7
10	Газардуулагчтай розетка далд угсрах	ш	8
11	Утас монтажлах 2*2.5мм2	м	120
12	Кабелийн утас монтажлах 2*4	м	10
13	D=15мм голчтой хуванцар хоолой угсрах	метр	50
14	Гал хамгаалагч угсрах	иж бүр	1

ТЭЖЭЭЛИЙН АГУУЛАХЫН ГАЗАР ШОРООНЫ АЖИЛ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Суурийн ажил ухах	м3	28.2
2	Багана, суурь цутгах м200	м3	27.1
3	Хүрмэн бетон гулдмайгаар хана өрөх	м3	14

ТЭЖЭЭЛИЙН АГУУЛАХЫН ЦУТГАМАЛ БАГАНА, ТӨМӨР БЕТОН БҮСНИЙ АЖИЛ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Хэв хашмалтай бүс төмөр бетоноор цутгах м-150	м3	19

ТЭЖЭЭЛИЙН АГУУЛАХЫН ДЭЭВРИЙН АЖИЛ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Шувуун нурууны бэхэлгээ суулгах	тн	0.049
2	Банзан шувуу нуруу угсрах	м3	13.26
3	Дээврийн сараалж банз хадах	м2	212
4	Цэвэр банзан карниз угсрах	м2	9
5	Хөндлөн холбоос угсрах	м2	36
6	Төмөр дээвэр хийх	м2	405
7	Дээврийн хормойвчийг төмрөөр хийж усны хагалбар гаргах	м2	12
8	Дээврийн малгайвч төмөр хийх	м2	30.8
9	Дээврийн сараалж ба хучаасын модон хийцүүдэд галаас хамгаалах бодис түрхэх	м2	220

ТЭЖЭЭЛИЙН АГУУЛАХЫН ШАЛНЫ АЖИЛ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Бетон бэлтгэл хийх м50-75	м3	14.4
2	20 мм зузаан цементэн тэгшилгээ хийх	м2	288

ТЭЖЭЭЛИЙН АГУУЛАХЫН ХААЛГА, ЦОНХНЫ АЖИЛ

АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Хаалганд төмөр рам суулгах	тн	0.01
2	Хаалганд холбоос туузан ган бэхлэх	тн	0.032
3	Гадагшаа онгойдог том хаалга ТХ40-40	ш	2
4	Хананд төмөр хайс угсрах	м2	220

ТЭЖЭЭЛИЙН АГУУЛАХЫН ДОТОР,ГАДНА ЗАСЛЫН АЖИЛ

Д/Д	Ажлын нэр	Нэгж	Тоо хэмжээ
1	Хананд шавардлага хийх	м2	88
2	Дотор,гадна хана шохойн будгаар будах	м2	88